



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 27,000,000.00 (хорин долоон сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэх;


2.3.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

00000000

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2018 оны 06 дугаар сарын 21-ны
өдрийн 22 дугаар тогтоолын хавсралт

**Булган аймгийн Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашин**

д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Ландкрузейр-80 маркийн, 0007 БУА улсын дугаартай, Арлын дугаар - JT3DJ81WOP0032512	1993/2001	235000	27,000,000.00	27,000,000.00	0.00		4,000,000.00
				27,000,000.00	27,000,000.00	0.00	0.00	4,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			27,000,000.00 (хорин долоон сая)	27,000,000.00 (хорин долоон сая)			4,000,000.00 (дөрвөн сая)